

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэт-гэлийн хувь
ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ. /“Алсын хараа-2050” зорилт 5.3, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.3, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Улсын бүртгэлийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө/							
ЗОРИЛТ1. ДЭВШИЛТЭД ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА БАЙНА.							
1.1.	Төр, хувийн хэвшлийн байгууллагууд цахим тамга, иргэд тоон гарын үсгийг бүртгэлийн үйлчилгээнд таньж баталгаажуулах боломжийг бүрдүүлэх	-	Тоон гарын үсэг олголтыг нэмэгдүүлэх.	7431	8000	2025 онд өссөн дүнгээр 569 иргэнд тоон гарын үсэг олгохоор төлөвлөсөн. 2025 оны эхний хагас жилд Гурвантэс суманд байршуулсан киоск машинаар 465 иргэнд, Ханбогд суманд байршуулсан киоск машинаар 412 иргэнд, Цогтцэций суманд байршуулсан киоск машинаар 465 иргэнд нийт 1342 иргэнд, улсын бүртгэгч нараас 1448 иргэнд нийт хүсэлт ирүүлсэн 2790 иргэнд тоон гарын үсэг олгож шийдвэрлэсэн.	100%
			Тоон гарын үсгийг бүртгэлийн үйлчилгээнд таньж баталгаажуулах, хэрэглээнд нэвтрүүлэхэд санал хүргүүлэх.	-	1	Улсын бүртгэлийн үйлчилгээнд тоон гарын үсгээр таньж баталгаажуулах, хэрэглээнд нэвтрүүлэх талаарх саналыг 2025 оны 01 дүгээр сарын 26 ны өдөр УБЕГ-азарт хүргүүлсэн.	100%
1.2.	Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд өгөгдлийн шинжилгээ хийх	-	Үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийсэн тоо	1	4	Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээ хийж улсын бүртгэгч нарын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор нийт улсын бүртгэгчийн бүртгэлийн тоо, төрөл, ажлын ачааллыг харьцуулсан судалгааг гаргаж УБЕГ-т санал хүргүүлсэн. Нийт 2 удаа	50%

			Шинжилгээний үр дүнд хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	1	Өгөгдлийн шинэчилгээ хийсний дагуу Баяндалай, Номгон, Ноён сумдын улсын бүртгэгч нарт гадаад паспорт хөтлөх эрхийг шинээр нээж нийт 6 сумдад гадаад паспортын бүртгэл хөтлөж байна.	100%
1.3.	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байдалд хяналт тавих	-	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хувь	100%	100%	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж shilendans.gov.mn сайтад хагас жилийн байдлаар санхүүгийн тайлан болон холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж, хугацаа хоцроосон мэдээ, мэдээлэл байхгүй.	100%
			Хугацаандаа байршуулсан мэдээний тоо	171	171	2025 оны 05 дугаар сарын 31 -ний өдрийн байдлаар хэлтсийн санхүүгийн үйл ажиллагааны тайлан, мэдээллийг бүрэн гаргаж хагас жилийн байдлаар Нийт 68 удаа мэдээлэл байршуулахаас 68-г байршуулсан байна.	100%
ЗОРИЛТ 2. ОРЧИН ҮЕИЙН ШИНЭ ТЕХНИК, ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЖ, ТӨРӨӨС ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮЗҮҮЛЭХ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ШУУРХАЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.							
2.1.	Улсын бүртгэлийн үйлчилгээг хууль, журмын хүрээнд үнэн зөв, шуурхай хүргэх.	-	ИУБүртгэлийн үйлчилгээний тоо	26482	26500	2025 оны эхний хагас жилийн байдлаар төрсний бүртгэл 482, гэрлэсний бүртгэл 170, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 43, үрчилсний бүртгэл 8, эцэг /эх/ тогтоосны бүртгэл 29, овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчисний бүртгэл 34, нас барсны бүртгэл 164, нийт олгосон иргэний үнэмлэхний бүртгэл 1417, үндэсний энгийн цахим гадаад паспортын бүртгэл 2930, шилжилт хөдөлгөөний 4205 бүртгэл бүртгэж иргэн хуулийн этгээдэд 3879 лавлагаа олгосон. Нийт 13361 бүртгэл	50,4%
			ЭХЭУБүртгэлийн үйлчилгээний тоо	12425	12500	- Эд хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэлд 1201 иргэний өмчлөх эрхийг баталгаажуулсанаас: Төрөөс үнэгүй хувьчилсан газар өмчлөх эрхийн бүртгэл 750, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн бүртгэл 451 хүсэлт хүлээн авч бүртгэсэн. - Гэрээний эрхийн нийт 4078 бүртгэгдсэнээс: Худалдах, худалдан авах	47,5%

						гэрээ 827, бэлэглэх гэрээ 111, арилжих гэрээ 35, гэрээслэл болон өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх эрхийн бүртгэл 63, хамтран өмчлөгч өөрчлөгдөх 47, эрх бүхий этгээдийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх 1, барьцааны гэрээ 1769, барьцааны эрх дуусгавар болгох 1216, бусад гэрээ 9 тус бүртгэсэн. • Эрхийн улсын бүртгэлд өөрчлөлт залруулгаар 634 бүртгэл бүртгэсэнээс: бүртгэлд өөрчлөлт оруулсан 450, урьдчилсан тэмдэглэл хийх 1, хувийн хэрэг хаах бүртгэл 27 тус тус бүртгэсэн. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 156 лавлагаа мэдээллийг олгосон. • Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд ирүүлсэн 33 онлайн мэдүүлгийг хүлээн авснаас 20 барьцааны гэрээг дуусгавар болгож, 13 хүсэлтийг татгалзаж шийдвэрлэсэн. Нийт-5946 бүртгэл	
			ХЭУБүртгэлийн үйлчилгээний тоо	3700	3750	2025 оны 05 дугаар сарын 25ны өдрийн байдлаар хуулийн этгээдийн нийт 1787 улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлсэн байна. Үүнд: • Хуулийн этгээд нэрийн баталгаажуулалт - 432 • Шинээр үүсгэн байгуулсан хуулийн этгээд - 335 • Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт - 380 • Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ дахин олгосон - 111 • Хуулийн этгээдийн бүртгэлийн лавлагаа олгосон - 21 • Хуулийн этгээд татан буулгасан бүртгэл – 3 • Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулах салбар - 32	100%

						• Хуулийн этгээдэд олгосон тамга, тэмдэгийн хяналтын хуудас - 429 • Хуулийн этгээдээс хураан авсан тамга, тэмдэг - 38 • Хуулийн этгээдийн бүртгэлд хориг тавьсан, цуцалсан – 6 бүртгэлийн тус тус хөтөлж баталгаажуулсан. 2025 оны 05 дугаар сарын 25 ны өдрийн байдлаар нийт 5913 мэдүүлэг хүлээн авч улсын эрхийн бүртгэлд баталгаажуулсан.	
2.2.	Улсын бүртгэлийн цахим үйлчилгээг өргөжүүлэх	-	И-Бизнес порталаар бүртгэсэн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тоо	264	280	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн И-Бизнес цахим сүлжээгээр нийт 1843 хүсэлт хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн хуулийн этгээдийн 137 нэр баталгаажуулж, 1698 хүсэлтийг бүртгэхээс татгалзсан, 8 цахим гэрчилгээ баталгаажуулсан.	48.9%
			И-Монголиа порталаар бүртгэсэн иргэний улсын бүртгэлийн тоо	272	300	Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia цахим системээр Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн 223 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн. Гадаад паспорт захиалах 14, иргэний үнэмлэх дахин захиалах 15 хүсэлтийн дагуу хэвлэгдэн ирсэн бичиг баримтыг иргэдэд түргэн шуурхай олгож нийт 252 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.	84%
2.3.	Улсын бүртгэлийн үйлчилгээг хөдөлгөөнт хэлбэрээр үзүүлэх	-	Үйлчилгээ үзүүлсэн тоо	10	20	➢ 2025 оны 01 дүгээр сарын 14-15 ны өдөр Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Бага-Овоо 5 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах хилийн цэргийн 0166 дугаар ангид “Улсын бүртгэлийн нэг цэг”-ийн үйлчилгээ зохион байгуулж иргэний улсын бүртгэлийн 93, ХЭ,ЭХЭУБүртгэл 46 иргэнд, улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн. ➢ 2025 оны 02 дугаар сарын 24 ний өдөр Өмнөговь аймгийн Баяндалай, Сэврэй суманд “Улсын бүртгэлийн нэг цэг”-ийн үйлчилгээ зохион байгуулж нийт	60%

						97 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж 160 гаруй иргэнд, ➤ 2025.03.24 - 2025.04.07 ны өдрүүдэд Өмнөговь аймгийн ЗДТГазраас зохион байгуулсан “Өсөлттэй Өмнөговь - Өсөлттэй ЖДҮ” арга хэмжээний хүрээнд “Зөвлөө-Туслая” нэг цэгийн үйлчилгээнд улсын бүртгэгч З.Хасар ажиллаж хуулийн этгээдийн улсын үйлчилгээ үзүүлж, мэдээлэл зөвлөгөө өгсөн. ➤ 2025.04.15 ны өдөр Өмнөговь аймгийн Ханбогд сумын 5 -р баг Хайрхан, Цагаан хад суурьшлын бүсэд зохион байгуулагдсан “Танд ойрхон төрийн үйлчилгээ-2025” нэг цэгийн үйлчилгээнд Ханбогд сумын лсын бүртгэгч У.Цэенням иргэний улсын бүртгэл 48, хэ,эхэүбүртгэл 87 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлж, 24 иргэнд “Тоон гарын үсэг” олгож давхардсан тоогоор 135 иргэнд мэдээлэл зөвлөгөө өгсөн. ➤ 2025.04.23 ны өдөр Өмнөговь аймгийн Баяндалай, Гурвантэс сумдуудад “Иргэдээ сонсох өдөрлөг” зохион байгуулж тус өдөрлөгөөр 76 иргэнд , ➤ 2025 оны 05 дугаар сарын 01 ний өдөр Монголын Хуульчдын холбооноос зохион байгуулсан “Про-Боно-2025” өдөрлөгт оролцож 140 гаруй иргэд, ➤ 2025.05.03 ны өдөр “Татвар төлөгчдийн өдөр 2025” арга хэмжээг тохиолдуулан Өмнөговь аймгийн Ханбогд сумын 1 дүгээр сургуультай хамтран “Нэг цэг”-ийн үйлчилгээг зохион байгуулж 12 иргэнд, ➤ 2025 оны 05 дугаар сарын 13-16 ны өдрүүдэд “Мэдээллийг мэргэжилтнээс” аяны хүрээнд Өмнөговь аймгийн	
--	--	--	--	--	--	---	--

						Номгон улсын бүртгэгч М.Уранцэцэг тус сумын төрийн болон, төрийн бус байгууллагын нийт 53 иргэнд, ➤ 2025 оны 05 дугаар сарын 15 ны өдөр Өмнөговь аймгийн Сэврэй суманд иргэний улсын бүртгэгч Б.Баясгалан “Улсын бүртгэлийн нэг цэг”-ийн үйлчилгээ үзүүлж нийт 53 иргэнд, ➤ 2025 оны 05 дугаар сарын 17 ны өдөр Өмнөговь аймгийн Хөгжимт жүжгийн театрт Улсын бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээ зохион байгуулж иргэний улсын бүртгэл-120, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл 80 иргэнд нийт 200 иргэнд, ➤ 2025.05.28- 29 ны өдрүүдэд Баяндалай сумын 3 багийн Иргэдийн нийтийн хурлаар “Явуулын оффис”-ийн үйлчилгээ зохион байгуулагдаж улсын бүртгэгч А.Цэрэндолгор оролцож 40 иргэнд, ➤ 2025.05.28-30 ны өдрүүдэд Цогт-Овоо сумын 3 багийн өдөрлөг зохион байгуулагдаж, улсын бүртгэгч С.Мөнхбаяр оролцож 350 гаруй иргэнд тус тус улсын бүртгэгч үйлчилгээг 12 удаа зохион байгуулсан.	
2.4.	Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин (Киоск)-оор үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх	-	Киоскоор үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээний төрлийн тоо	13988	14000	2025 оны эхний хагас жилийн байдлаар “Киоск” машинаас цахим гадаад паспортын захиалга 20, гадаад паспортын лавлагаа 27, цахим үнэмлэхний лавлагаа 2579, байнга оршин суугаа хаягийн лавлагаа 810, гэрлэсний бүртгэлгүй тухай лавлагаа 38, гэрлэлтийн лавлагаа 79, гэрлэлт дуусгавар болсон лавлагаа 2, төрсний бүртгэлийн лавлагаа 38, овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр өөрчилсөний лавлагаа 1, регистрийн дугаарын лавлагаа 4, регистрийн дугаар өөрчилсний бүртгэлийн лавлагаа 2, хуулийн этгээдийн бүртгэлтэй	70%

						эсэх лавлагаа 165, хуулийн этгээд бүртгэлгүй тухай лавлагаа 207, хуулийн этгээдийн хаягийн лавлагаа 131, эд хөрөнгийн лавлагаа 2886, эд хөрөнгөтэй эсэх лавлагаа 1145, тоон гарын үсэг 1342 иргэнд Нийт 9476 үйлчилгээг иргэдэд үйлчилсэн.	
2.5.	Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих замаар улсын бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг хангах.	-	Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь.	100%	100%	Хяналтын улсын байцаагч Төлөвлөгөөт шалгалт 23, Гэнэтийн болон төлөвлөгөөт бус шалгалт 15, өргөдөл 34 нийт 72 удаагийн хяналт шалгалтаар шилжилт хөдөлгөөний бүртгэл, иргэний гэр бүлийн байдлын 8 төрлийн бүртгэлийн бүрдүүлбэр материалын 2756 бүртгэлд, хуулийн этгээдийн шинээр үүсгэн байгуулагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон 135 бүртгэлийн бүрдүүлбэр материалд, газар өмчлөх эрхийн бүртгэл, барьцаат зээлийн гэрээ, БЗГэрээ дуусгавар болгосон, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэлийн 606 бүртгэлийн бүрдүүлбэр материалд, нийт 3497 бүртгэлд хяналт шалгалт хийж, иргэний бүртгэлийн чиглэлээр 2, хуулийн этгээдийн бүртгэлээр 7, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 15 нийт 34 дүгнэлтийг үйлдэж Хяналт шалгалтын газарт хүргүүлж, зөрчлийг бүрэн шийдвэрлэсэн.	100%
2.6.	Улсын бүртгэлийн байгууллагын 2025 оны үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх	-	Батлагдсан эрсдэлийн төлөвлөгөөний тоо	1	1	2025 оны Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг боловсруулж, Тус төлөвлөгөөнд тусгагдсан эрсдэлийг “Улсын бүртгэлийн байгууллагын эрсдэлийг бууруулах төлөвлөгөө”-нд тусгуулахаар УБЕГ-т саналыг хүргүүлсэн.	100%

			Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	20%	25%	Эрсдэлийн төлөвлөгөөнд тусгуулсан ажлын эрсдэлийг бууруулах зорилгоор улсын бүртгэлийн тухай хуулийн болон төсвийн төсөлд санал хүргүүлсэн.	10%
2.7.	Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд Улсын бүртгэлийн багц хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд санал хүргүүлэх	-	Хуулийн төсөлд санал хүргүүлсэн тоо.	1	1	Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн төсөлд 1 удаа, ЭХЭУБүртгэлийн тухай хуулийн төсөлд 2 удаа, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд 1 удаа тус тус нийт 4 удаа санал хүргүүлсэн.	100%
ЗОРИЛТ 3. УЛСЫН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, НЭГДСЭН САНГИЙН НУУЦЛАЛЫГ ХАНГАН, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.							
3.1.	Тог баригч, бусад тоног төхөөрөмжийн эд ангийн засвар үйлчилгээг хийж гүйцэтгэх.		Засвар үйлчилгээ хийсэн тоо	8	10	Иргэд өөртөө үйлчлэх “ДӨТ” машины засвар үйлчилгээг ханган 3 удаагийн гэмтлийг шалган засварлаж хэвийн ажиллагаанд оруулсан. Гурвантэс сумын ДӨТ машиныг форматлаж шаардлагатай программ хангамжийг суулган таниулж, сүлжээнд холбож хэвийн ажиллагаанд оруулсан. Хагас жилийн байдлаар нийт 5 компьютер форматлаж, 3 компьютерийн шуурхай санах ойг сольсон.	50%
3.2.	Цахим мэдээллийн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээний хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангаж ажиллах.		Мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдал, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах чиглэлээр хийсэн арга хэмжээний тоо	1	2	Мандал-Овоо сумын дотоод сүлжээ 2 удаа, Цогтцэций сумын дотоод сүлжээ 1 удаа доголдсоныг тухай бүрт шалгаж шаардлагатай арга хэмжээг авч хэвийн ажиллагааг хангасан.	100%
3.3.	Төрийн аудитын газраас ирүүлсэн зөвлөмжид хяналт тавих, мэдээ мэдээлэл, тайланг хугацаанд нь хүргүүлэх.	-	Зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийн хувь.	100%	100%	Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайланг Өмнөговь аймгийн Төрийн Аудитын газарт шалгуулж, өөрчлөлтгүй дүгнэлт авч, ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%

ЗОРИЛТ 4. ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭН, ГАДААД ОРНЫ БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУРШЛАГААС БАЙГУУЛЛАГЫН ОНЦЛОГТ ТОХИРУУЛАН ХЭРЭГЖҮҮЛНЭ.							
4.1.	Бусад Улсын бүртгэлийн хэлтэстэй харилцан туршлага солилцох.		Харилцан туршлага солилцох алба хаагчдын тоо	15	20	2025.04.17-19 ний өдөр Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний түүхт 85 жилийн ойн арга хэмжээнд ажилтан албан хаагчдын бие бялдарыг хөгжүүлэх, туршлага солилцох сургалтад Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 10 албан хаагч очиж харилцан туршлага солилцсон. 2025 оны сүүлийн хагас жилд Дорноговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэстэй харилцан туршлага солилцохоор төлөвлөсөн.	50%
ЗОРИЛТ 5. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛНЭ.							
5.1.	Улсын бүртгэлийн хэлтсийн 2025 оны Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх.	-	Төлөвлөгөөг боловсруулж хэрэгжилтийг хангасан хувь	100	100	2025 оны хагас жилийн Авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилт болон авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг гаргаж 2025.05. сард УБЕГ-т хүргүүлсэн.	100%
5.2.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	-	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд хүргэсэн тоо	15	18	Улсын бүртгэлийн хэлтсийн цахим хуудсанд байршуулсан АТГ-аас бэлтгэсэн “Авлигатай тэмцэх газрын мэдээлэл” нэвтрүүлэг, “110 подкаст”, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хорооны анхдугаар хуралдаанаас гарсан шийдвэрүүд” зэрэг мэдээллийг share хийж олон нийтэд 10 удаа хүргэсэн.	70%
ЗОРИЛТ 6. МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.							

6.1.	Эцсийн өмчлөгчийн мэдээллийн чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулах	-	Ижил түвшний бүртгэлийн байгууллагатай хамтран ажиллах замаар туршлага солилцох, сургалтанд хамрагдсан албан хаагчдын тоо	0	1	Эцсийн өмчлөгчийн мэдээллийн чанарыг сайжруулах ажлыг 3-р улиралд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	50%
ЗОРИЛТ 7. ЧАДАХУЙН ЗАРЧИМД СУУРИЛСАН ХҮНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЖ, АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАНА.							
7.1.	Байгууллагын 2025 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	-	Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	Хэлтсийн 2025 онд зохион байгуулагдах сургалтын төлөвлөгөөний дагуу Хууль хяналтын байгууллага АЗДТГ-ын ХЭЗХэлтэс, Банк, банк бус санхүүгийн байгууллага, Сумдын ЗДТГазар, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран 19 удаагийн сургалтуудыг зохион байгуулж, хэлтсийн нийт албан хаагчдын дунд 2 удаа хэлэлцүүлэг өрнүүлсэн.	100%
7.2.	Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025-2028 онд хэрэгжүүлэх “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр” боловсруулан хэрэгжүүлэх.	-	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	100	100	Бүгд Найрамдах Солонгос Улсад зохион байгуулагдсан “Улсын бүртгэлийн чадавхийг бэхжүүлэх” сургалтад Хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Нямсамбуу, , “Шихихутуг их сургууль”-д эрх зүйч мэргэжлээр Улсын бүртгэгч О.Жижигчулуун нарыг тус тус суралцах боломжоор хангасан. 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Хууль зүй дотоод хэргийн сайдын санаачилгаар УБЕГазраас зохион байгуулж буй “Хамгийн чухал нь” хөтөлбөрийн хүрээнд Төрийн тусгай албан хаагчдийн нэгдсэн эмнэлгийн эрүүл мэндийн эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд 28 албан хаагч болон тэдгээрийн гэр бүлийг хамруулсан. Цэцэрлэгийн болон бага ангийн хүүхэдтэй	100%

						ажилтан, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эх, хөгжлийн бэрхшээлтэй болон байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай өрхийн гишүүнтэй ажилтан, өрх толгойлсон эцэг, эхэд, гэр бүлээ батлуулсан өдөр, хүүхдийн төрсөн өдөрөөр цалинтэй чөлөө олгох, гэр бүлийн өдрийг гэр бүлийн хүрээнд тэмдэглэн өнгөрүүлэх зорилгоор давхардсан тоогоор 15 албан хаагчдад тус тус цалинтай чөлөө олгосон.	
7.3.	Албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтөлж эхлэх	-	Албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтөлсөн хувь	-	100	Албан хэргийн кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөх ажлыг зохион байгуулж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.	50%
7.4.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/110 дугаар тушаалаар баталсан “Хамгийн чухал нь” зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх	-	Үзлэг, оношилгоонд албан хаагчдын хамрагдсан хувь	-	70	2025 оны 05 дугаар сарын 10 ны өдөр Хууль зүй дотоод хэргийн сайдын санаачилгаар УБЕГазраас зохион байгуулж буй “Хамгийн чухал нь” хөтөлбөрийн хүрээнд Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн “Эрүүл мэндийн эрт илрүүлэг, үзлэг оношилгоо”-нд Улсын бүртгэлийн хэлтсийн 28 албан хаагчид болон тэдний гэр бүлийн 5 (насанд хүрсэн) гишүүдийг хамруулсан.	100%
7.5.	“Тэрбум мод” хөдөлгөөнийг хэрэгжүүлэх	-	Шинэ модны тоо	30	50	- “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд бүх нийтээр мод тариалж 2025 оны 04 дүгээр сарын 25 ны өдөр Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид нийт шинэр 90 модны суулгацыг ногоон хэрмийн 12-р га талбайд суулгасан.	100%
			Нөхөн тарилтын хувь	100	100	Улсын бүртгэлийн байгууллага үүсэж хөгжсөний 85 жилийн ойг угтан Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид “Улсын бүртгэлийн төгөл” нэртэй байгаль орчныг хамгаалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх санаачилгыг хэрэгжүүлэн энэхүү ажлын хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 30 ны өдөр байгууллагынхаа хашаанд өөрсдийн нөөц	100%

						бололцоонд тулгуурлан 40 модыг шинээр суулгаж, 25 модыг нөхөн тарьж нийт 200 модтой төгөл байгуулахаар төлөвлөж байна.	
ЗОРИЛГО. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ “ӨСӨЛТТЭЙ ӨМНӨГОВЬ” ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							
Зорилт 8. Төрийн үйлчилгээг хүний эрхийг дээдлэх, иргэдийн оролцоог хангаж ёс зүйтэй, хариуцлагатай, шуурхай, хүртээмжтэй, ил тод хүргэнэ.							
8.1.	Улсын бүртгэлийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	Орон нутгийн санхүүжилт	Иргэний үнэмлэх, үндэсний энгийн цахим гадаад паспорт хэвлэх тоног төхөөрөмжийг нэвтрүүлсэн тоо	-	1	Өсөлттэй Өмнөговь хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 350 сая төгрөгийн Иргэний үнэмлэх, үндэсний энгийн цахим гадаад паспорт хэвлэх тоног төхөөрөмжийг худалдан авах төсвийг шийдвэрлүүлсэн. УБЕГ-ын 2025 оны 4 сарын 9 ны 1/4962 тоот Иргэний үнэмлэх, үндэсний энгийн цахим гадаад паспорт хэвлэх тоног төхөөрөмжийг худалдан авах нууцлал, аюулгүй байдлыг хангах зөвлөмжийг холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлсэн.	60%
			Үйлчилгээ үзүүлсэн хувь	-	100	2025 оны сүүлийн хагас жилд хийгдэхээр төлөвлөсөн.	50%
8.2.	“Нутгийн дэм” хөтөлбөрт алба хаагчдыг бүрэн хамруулах.	Орон нутгийн санхүүжилт	“Нутгийн дэм” хөтөлбөрт хамрагдсан албан хаагчдын тоо	28	28	Улсын бүртгэлийн хэлтсийн 29 албан хаагч “Нутгийн дэм, орон нутгийн дэм хөтөлбөрөөр 2025 оны 05 сарын байдлаар 61.137.727 төгрөгний дэмжлэг авч олгосон.	100%
8.3.	Байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, тусламж дэмжлэг үзүүлэх асуудлыг журмын дагуу шийдвэрлүүлэх	Аймгийн ЗДТГазрын санхүүжилт	Ипотекийн зээлд дэмжлэг авсан албан хаагчдын тоо	3	3	“Улсын бүртгэлийн эх нотлох баримтын хадглалат, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс тус хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 9 албан хаагчийн орон сууц захиалах нэрсийг 2025 оны 06 дугаар сарын 10-нд УБЕГ-т хүргүүлсэн.	100%

8.4.	Төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг нэмэгдүүлэх	Орон нутгийн санхүүжилт	Шинэчлэгдсэн тоног төхөөрөмж, эд хөрөнгийн тоо	10	15	Явуулын үйлчилгээ үзүүлэх зорилгоор Баяндалай, Булган, Манлай сумын улсын бүртгэгч нарт орон нутгийн санхүүжилтээр 3 ширхэг зөөврийн тоног төхөөрөмжийг шийдвэрлүүлсэн.	20%
8.5.	Аймгийн ИТХурлын 2022 оны 12 дугаар сарын 01 ны өдрийн 9/9 дүгээр тогтоолоор Даланзадгад суманд шинээр байгуулагдсан 9, 10 дугаар багийн иргэдийн бичиг баримтыг шинэчлэх ажлыг эрчимжүүлэх	Аймгийн ЗДТГазрын нөөц хөрөнгө	Даланзадгад суманд шинээр байгуулагдсан 9, 10 дугаар багийн иргэдийн бичиг баримтыг шинэчилсэн тоо	685	700	Аймгийн ИТХурлын 2022 оны 12 дугаар сарын 01 ны өдрийн 9/9 дүгээр тогтоолоор Даланзадгад суманд шинээр байгуулагдсан 9 дүгээр багийн 78 иргэнд өмчлөх эрхийн гэрчилгээ, 10 дугаар багийн 39 иргэдийн өмчлөх эрхийн гэрчилгээний хаягийг шинэчилж, иргэний үнэмлэхийг шинэчлэх хүсэлт гаргасан 12 иргэний хүсэлтийг бүртгэж нийт 139 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн.	100%
8.6	“Эрүүл шүд” хөтөлбөрт албан хаагчдын хүүхдүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	-	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо	47	48	“Эрүүл шүд” хөтөлбөрийн хүрээнд УБХэлтсийн Эрүүл мэндийн зөвлөл үе шаттай ажлыг зохион байгуулж хагас жилд албан хаагчдын ЕБСургуулийн 1-3 ангийн хүүхдийг хамруулахаар төлөвлөж нийт 16 хүүхдийг ЕБСургууль, БОЭТ-ийн шүдний тасагтай хамтран урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд бүрэн хамруулсан.	100%
8.7	“Хүүхдээ сонсох өдөр”-ийг зохион байгуулах	-	Зохион байгуулсан тоо	11 удаа	11 удаа	2025 оны 2, 3, 4, 5 сарын 2 ны өдөр “Хүүхдээ сонсох өдөр” арга хэмжээг зохион байгуулж хэлтсийн алба хаагчдын 13 хүүхэд оролцож, Улсын бүртгэлийн хэлтсийн хүүхдийн өрөөнд тоглох, хичээл, гэрийн даалгавраа хийх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөхөд шаардлагатай зүйлсэд санал, хүсэлтээ зургаар болон бичгээр илэрхийлэн ирүүлсний дагуу эцэг эхчүүд өөрсдийн нөөц бололцоогоор дэмжин ажиллаж байна.	100%
8.8	Албан хаагчийн гэр бүлээ батлуулсан өдөр, хүүхдийн төрсөн өдөр цалинтай чөлөө олгох	-	Цалинтай чөлөө олгосон албан хаагчдын тоо	45	45	Байгууллагын ажилтан, албан хаагчдын гэр бүлийн хүрээнд гэр бүлээ батлуулсан өдөр 5, хүүхдийн төрсөн өдрийг тэмдэглэн өнгөөрөх 10 албан хаагчдад цалинтэй	100%

						чөлөө олгож, гэр бүлийн үнэ цэнийг нэмэгдүүлэн, гэр бүл, үр хүүхдүүдтэйгээ дурсамж бүтээх цагийг бүрдүүлэн ажиллаж байна.	
--	--	--	--	--	--	---	--

Тайланг үнэлсэн: **Төсвийн төвлөрүүлэн захирагч**

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ /У.БОЛДХҮҮ/

(албан тушаал) (гарын үсэг).....(огноо)

Нэгжийн дарга

Хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн:
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА...../Т.ГАНТӨМӨР/
(албан тушаал) (гарын үсэг).....(огноо)

Тайлагнасан: **Нэгжийн дарга**

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ /Т.НЯМСАМБУУ/

(албан тушаал) (гарын үсэг).....(огноо)

-